

# ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДАЛД ШИЛЖИХ ТУХАЙ

Эрүүл мэндийн газар

## Эрх зүйн баримт бичиг

- Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2
- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.4
- Засгийн газрын 2024 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол-**Өвөлжилт** хүндэрсэнтэй холбогдуулан улсын хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд **Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй**
- УОК-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэр
- “Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх тухай ЭМС-ын 2024 оны 02 сарын 19-ны А/69 дүгээр тушаал”

# “Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх тухай ЭМС-ын 2024 оны 02 сарын 19-ны А/69 дүгээр тушаал”

1.Монгол орны нийт нутаг дэвсгэрт өвөлжилт, хаваржилт хүндэрч байгаатай холбогдуулан бэлэн байдлыг хангах зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 05 дугаар 15-ны өдөр хүртэлх хугацаанд эрүүл мэндийн салбарыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсүгэй

2.Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн байгууллагын өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах түр журмыг хавсралтаар баталсугай.

3.Малчид,иргэдэд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх,шаардлагатай тохиолдолд орон нутагт ажиллуулах хөтөлбөр бүхий баг томилох, эмнэлгийн ажилчдыг мэргэжил арга зүйгээр ханган сургалт зохион байгуулж ажиллахыг СЭМҮТ-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

# Эрүүл мэндийн байгууллагын өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах түр журам

## **Нэг.Нийтлэг үндэслэл:**

1.1.ЭМБ-уудыг өндөржүүлсэн бэлэн байдлын горимд шилжин ажиллах харилцааг энэхүү түр журмаар зохицуулна.

1.2.ЭМБайгууллага нь энэхүү горимыг үндэслэн байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиг үүрэгтэй нийцүүлэн **өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах** бөгөөд энэ нь тухайн байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байна.

## **Хоёр. Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл:**

2.1.Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн талаар байгууллагын ажилтан ,албан хаагчдад танилцуулан үүрэг чиглэл өгч,зохион байгуулалтын арга хэмжээ авах

2.2. Өндөржүүлсэн бэлэн байдалд ЭТҮ-ний бэлэн байдлыг хангаж, ажиллах хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур,тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хүчилтөрөгчийн хангамж, унаа шатахууны нөөцийг бүрдүүлэх

2.3.Өндөржүүлсэн бэлэн байдлын үед гарсан шийдвэр,үүрэг чиглэлийг тухай бүрт хэрэгжүүлж ажиллах

# Эрүүл мэндийн байгууллагын өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах түр журам

2.4.Бүх шатны ЭМБайгууллага бүр бэлэн байдлын тусгай горимд шилжин цагийн хуваарийн дагуу ажиллах

2.5.Аймгийн ОБГ, Ус цаг уурын албанаас цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг тогтмол авч, эрсдэлийн үнэлгээг үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.6.Ажилтан албан хаагчдын ажил гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хоол хүнс, хувцас, техник хэрэгслээр хангах, аюулгүй ажиллагааг сахиулах, эрүүл мэндэд анхаарч ажиллах

2.7.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг хангаж, бүх шатны ЭМБ-ууд гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх

2.8.Өндөржүүлсэн блэн байдалд ажиллах дадлага,сургалтыг зохион байгуулж, ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулах

2.9.Байгууллага салбар нэгжийн хэмжээнд ажиллах **Шуурхай штаб, эргүүл жижүүрийг томилон** удирдлага,зохион байгуулалтаар хангаж ажиллах

2.10. Отроор өвөлжиж буй эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг 14 хоног тутамд шинэчлэн нягталж, ЭМЯ-д ирүүлэх

# Эрүүл мэндийн байгууллагын өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах түр журам

ЭМС-ын 2020 оны А/418 дугаар тушаалын 3,4 дүгээр хавсралт, 2021 оны А/309 дүгээр тушаалын дагуу Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллах

2.12.Гамшиг тохиолсон үед сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх баг байгуулж, малчид иргэдэд сэтгэлзүйн зөвлөгөө,тусламж үзүүлэх

2.13. Зудтай холбоотой хорогдсон малын сэг зэмээс үүдэлтэй халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх,хариу арга хэмжээг эрчимжүүлэх

2.1.4.Нөхцөл байдал,авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар ЭМЯ-нд тухай бүрт шуурхай танилцуулах

2.1.5.ЭМГ нь өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байгаа тайланг 7 хоног бүрийн Баасан гаригийн 17.30 минутаас өмнө ЭМЯ-ны ЭТҮГ-т бичгээр болон цахимаар ирүүлэх

3.1.Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ, эрх үүргийг зөрчсөн ажилтан,албан хаагчдыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

# Малчдад явуулаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмч нарын хуваарь

№	Эмч нарын нэрс	Албан тушаал,албан газар	Холбогдох утас	Үзлэг хийх он сар өдөр
1	О.Лхамхүү	Учралтбаяр ӨЭМТ, эмч	99250354	2024.02.22
2	Ю.Сарантуяа	Үйлсбадрах ӨЭМТ,эмч	99971235	
3	Э.Угтахжаргал	Мэндцэцэн ӨЭМТ, эмч	99553296	2024.02.23
4	Д.Цэрэнбаатар	БОЭТ,хүүхдийн эмч	88109842	
5	Э.Бат-эрдэнэ	БОЭТ, яаралтай тасгийн эмч	80681991	2024.02.24



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41  
И-мэйл: letter@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2024.02.20 № 2/713  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аяны тухай

Монгол орны газар нутгийн 80 гаруй хувьд зудын нөхцөл байдал үүсч, 2024 оны 02 дугаар сарын 15-аас өндөржүүлсэн бэлэн байдал зарлаад байна. Цагаан зудын гамшигт нэрвэгдсэн малчдад туслах хандивын аян өрнүүлэх уриалгыг улсын хэмжээнд гаргасан. Эрүүл мэндийн яам энэхүү аяныг дэмжиж, эрүүл мэндийн нийт байгууллагуудад дэмжихийг уриалж байна.

Малчдад туслах аяныг дэмжин зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээллийг 2024 оны 02 дугаар сарын 27-ны дотор Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ үү.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.ТӨГСДЭЛГЭР



## “Малчдадаа тусалъя” аянд нэгдэх тухай

- Монгол улсын хэмжээнд өвөлжилт хүндэрч, зудын гамшигт нөхцөл байдал үүссэний улмаас малчдын амьжиргааны эх үүсвэр болсон мал сүрэг их хэмжээгээр хорогдож, хүний амь нас, эрүүл мэнд хохирох эрсдэл учирч байгаа тул сэтгэлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор “Малчдадаа тусалъя” аяныг Орхон аймгийн Эрүүл мэндийн газраас 2024 оны 02 сарын 22-ноос 2024 оны 02 сарын 29-ны өдрүүдэд зохион байгуулах гэж байгаа тул Эрүүл мэндийн салбар байгууллагуудад ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд та бүхнийг уг аянд нэгдэхийг уриалж байна.
- Уг аяны хүрээнд төлийн нэмнээ, уут, ажлын бээлий, дулаан хувцас, гурил будаа, цай давс, хужир, долооц, гар чийдэн, зай батерей, асаагуур, духны гэрэл, хуурай сүү, хөхөлт, угж, лаа шүдэнз, хуучин хөнжил, бүтээлэг, өвч тэжээл, буудай, түлээ түлш, ажилласан масло зэрэг эд зүйлсийг хандивт өгч болох бөгөөд цуглуулсан хандивыг аймгийн Онцгой байдлын газарт хүлээлгэн өгөх болно.
- Хандивын эд зүйлсийг хандивын бүртгэлийн хуудсын доорхи загварын дагуу ЭМГ-ын нярав Б.Алтанзагас, олон нийттэй харилцах ажилтан Б.Лхагвадэмбэрэл нарт хүлээлгэн өгнө үү Холбогдох утас: 99358934, 99366552

## МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛ

- Магадлан хэлэлцэх зөвлөл нь ЭМС-ын 2022 оны А/263 дугаар тушаалын дагуу 2023 оны 3, 4 дугаар улиралд бүртгэгдсэн амьгүй төрөлтийн-4, гэрийн төрөлтийн-2,5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн-8, эхийн ноцтой хүндрэлийн-1, нийт 15 тохиолдолд үзүүлсэн тусламж үйлчилгээг дүгнэн хэлэлцсэн.
- Эх хүүхдийн эндэгдэлд нөлөөлсөн хожимдлыг бууруулах, оношилгоо, эмчилгээтэй холбоотой сургамж, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлнэ.
- 2023 онд нялхасын эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 тохиолдлоор буюу 1,6 промиллоор нэмэгдсэн, нярайн эндэгдлийн 12 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор тус тус нэмэгдсэн .
- 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн 21 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6 тохиолдлоор өссөн буюу 1000 амьд төрөлтөд 2,5 п/мил-ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 2.Нялхасын эндэгдэлд эзлэх нярайн эндэгдэл 66,6% -ийг эзлэж, нярайн эрт үеийн эндэгдэл 8 буюу 66,6 %, нярайн хожуу үеийн эндэгдэл 33,4%-ийг эзлэж байна. Нярайн жингийн хувьд гүйцэд 4 буюу 33,4% , дутуу 8 буюу 66,6%-ийг эзлэж байна. 3.Нялхасын эндэгдлийн 72,3% БОЭТөвд эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, гэрт, гадаа 27,7 % нь эндсэн, 5 хүртэл насны хүүхдийн 21 тохиолдлын 71,5% эмнэлэгт, гэрт 28,5% эндсэн байна. Харьяалалын бус-5, харьяалалын 16 тохиолдол бүртгэгдсэн байна. 4.Нялхасын эндэгдлийн шалтгааны хувьд төрөлт тойрны эмгэг 66,6%, гадны шалтгаант осол гэмтэл 22,2%, төрөлхийн хөгжлийн гажиг 11,1% байна.
- Тав хүртэл насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд төрөлт тойрны эмгэг 57,1%, гадны шалтгаант осол гэмтэл-28,5%, төрөлхийн хөгжлийн гажиг 14,2% -ийг тус тус эзлэж байна. Сэргийлж болох эндэгдэл 6 буюу 28,5%-ийг эзлэж байна.
- 2023 онд эндсэн тав хүртэл насны хүүхдийн эндэгдлийн 21 тохиолдолд үзүүлсэн тусламж үйлчилгээг дүгнэн Магадлан хэлэлцэх зөвлөлийн хурлаар 100,0% хэлэлцүүлсэн, үүнээс онош зөрсөн -1, ЭҮД-д тооцогдсон-1, шүүх, эмгэг судлалын шинжилгээнд хамрагдсан хувь 95,2%-тай байна. Харьяалалын бус-5, харьяалалын 16 тохиолдол байна.

# Эх хүүхдийн тусламж үйлчилгээ

## Анхан шатлалын жирэмсний тусламж үйлчилгээнд:

- Жирэмснийг товлолын дагуу хянаагүй, дуудаж үзээгүй, жирэмсний хяналт хангалтгүй-7
- Жирэмсний хяналтад хожуу орсон-1
- ЖОХ-д шилжүүлэн хянах эрсдэлт бүлгийн эхийг шилжүүлээгүй-2
- ЖОХ-ын эмчтэй мэдээлэл солилцож, жирэмсэн эхийг үзүүлж буй эсэхэд хяналт тавиагүй-1
- ЭМС-ын 2019 оны “Журам батлах тухай” 318 дугаар тушаалын дагуу жирэмсний үзлэг бүрт эрсдлийг үнэлээгүй -4
- Өрхийн эмчийн зөвлөгөө хяналт хангалтгүй-8
- Гэрийн төрөлтөөс сэргийлэх зөвлөмж хангалтгүй-2
- 16-49 насны өртөмтгий бүлгийн гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээ хангалтгүй-5
- Эмчилгээ чанарын албаны үйл ажиллагааг чадавхжуулах, хурлыг чанаржуулах- 5
- ӨЭМТөвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний дотоод зохион байгуулалт хангалтгүй, хяналтын эмч олон дахин солигдсон-1
- Төрсний дараах зөвлөмжийг ар гэрт хангалтгүй өгсөн-1
- Хувь хүний хариуцлагатай холбоотой -3
- Зорилтот бүлгийн эмэгтэйчүүд, 16-49 насны эмэгтэйчүүдийн судалгааг улирал бүр тогтмол шинэчлэх шаардлагатай-5
- Анхан шатны бүрдэл, баримт бичиг дутуу хангалтгүй -1
- Явуулын, харьяаллын бус иргэдийн тусламж үйлчилгээнд анхаараагүй-2 байна.

## 2 дахь шатлалын төрөх үеийн тусламжүйлчилгээнд:

- ЖОХын эмчийн үзлэг хяналт хангалтгүй-2
- Хувийн хэвшлийн эмнэлгийн хяналт сул-1
- БОЭТ-ийн 103-ын эмч гэрт эндсэн хүүхдийн цогцосыг тээвэрлээгүй, задлан шинжилгээ хийгдээгүй-1
- Амьсгалын аппарат багаж тоног төхөөрөмжийн дутагдал-2
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хоорондын уялдаа холбоо сул-1 байна.

## *Нөлөөлсөн хожимдлыг тодорхойлж бууруулах чиглэлээр*

- ЭМС-ын 2019 оны А/318 дугаар тушаалын дагуу жирэмсэн үеийн эрсдлийн үнэлгээг зөв үнэлж, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд эрт шилжүүлэх, ЖОХ, өрхийн эмнэлгийн уялдаа холбоог нэмэгдүүлэх
- Жирэмсний хяналтын товллол, эрхтэн тогтолцооны эмгэг, эх барихын ужиг дурдатгалын чиглэлээр өрхийн эмчийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтанд хамруулах
- Хожуу давтан төрөгч, эх барих, эрхтэн тогтолцооны эмгэгтэй төрөх насны эмэгтэйчүүдийг гэр бүл төлөвлөлтөнд хамруулах
- Жирэмсэн үеийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх, гэрийн төрөлтөөс сэргийлэх зөвлөгөө өгөх
- Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийн талаар сургалт сурталчилгааг эрчимжүүлэх
- Хүүхдийн аминд аюултай шинж тэмдэгийг зааж сургах, эцэг эх асран хамгаалагчийн эмнэлгийн тусламж дуудах, сэргийлж болох эндэгдлийг бууруулах сургалт сурталчилгааг эрчимжүүлэх
- Хүүхдийг хөхөөр болон угжаар зөв хооллох талаар эцэг эх асран хамгаалагчдад зөвлөн туслах, зааж сургах
- Төрсөн эх, нярайд эхний 3 сарын хугацаанд туслах, эх, хүүхдийг асран сувилах талаар ар гэрт зөвлөгөө, мэдээллийг сайжруулах
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд харьяа баг, цагдаа, хүүхэд хамгааллын багтай хамтран эрсдэлт бүлэг, ялангуяа архины болон хувь хүний үүргээ биелүүлээгүй иргэд, эцэг эх, асран хамгаалагчдын судалгааг гаргаж, хариу арга хэмжээг авч ажиллах / архины эмчилгээнд хамруулах, хууль эрх зүйн сургалтад хамруулах /

## *Оношилгоо, эмчилгээтэй холбоотой сургамж зөвлөмж өгөх*

- Анхан шатлалын ЭМБ-уудын жирэмсний хяналтыг сайжруулах, жирэмсний үтрээний үрэвсэл, цус багадалтыг илрүүлж, эмчлэх, эрсдлийг зөв үнэлэх чиглэлээр эмч эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг нэмэгдүүлэх дотоодын сургалтыг ЭЧА-наас тогтмол зохион байгуулах
- Жирэмсэн эхийн чихрийн шижинг эрт илрүүлэх, эхийн жин, хэвлийн тойрог, ургийн жинг хэмжиж тооцоолж үнэлэх, ургийн өсөлтийн муруйг хэрэглэж хэвших, ДШБ-н эмчийн хяналт зөвлөгөө авах
- Жирэмсний онцгой хяналтын эмчийн ур чадварыг нэмэгдүүлэх, үзлэгийн тэмдэглэл, зөвлөгөөг дэлгэрэнгүй болгох, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах
- Жирэмсэн эхийг удирдамжийн дагуу хянах, үнэлэх, эмч, эх баригчийн ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, дотоодын сургалт зохион байгуулах, хүндрэх эрсдэлтэй эхийг зөв үнэлэх, буцааж хожимдол үүсгэхгүй байх
- Эхийн цетомегаловирусийн халдварыг илрүүлэх, шинжилгээнд үндэслэн нярайн хөхний сүүг сойх
- ЭМБ-уудын Эмчилгээ чанарын албадаас эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд хэрэгжиж байгаа стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын хэрэгжилтийг хангах, хожимдол чирэгдлийг бууруулахад анхаарч ажил зохион байгуулах, мэдээллийг шуурхай солилцож ажиллах
- Эх хүүхдийн тусламж үйлчилгээг стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалт, хүртээмжийг үнэлэх нэмэгдүүлэх
- Тохиолдол гарсан харьяа сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарыг тухайн тохиолдлын эмгэг судлалын шинжилгээнд дуудан оролцуулах ажлыг зохион байгуулах

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА**

